



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Г Албан тушаалын тодорхойлолт боловсруулах¹ ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6, Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Төрийн албаны Зөвлөлийн 2019 оны "Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай" 2 дугаар, "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах, нийтлэг журам батлах тухай" 3 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1469 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан байгууллагын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсон тул Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:
Гишүүд:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн (улсын байцаагч)
Дэд бүтцийн стандартын хэлтсийн ахлах мэргэжилтэн (улсын байцаагч)
Нарийн бичгийн дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахдаа төрийн бодлого, шийдвэр, байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан батлагдсан загвар, нийтлэг журмын дагуу 2023 оны 1-р улиралд багтаан боловсруулж ажиллахыг Ажлын хэсэг (Э.Даваахатан)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

d:\hotiin_standart\2023_b_tushaal_blank.docx

1150500061